

Хувьцаа ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

2025 оны 03 сарын 29



lendmn

Агуулга

- **Мэндчилгээ**
- **Хурлаар хэлэлцэх асуудал**
- **Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг**
- **Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт**
 1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 25/07 тоот тогтоол
 2. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 25/03 тоот тогтоол
 3. Компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх дүгнэлт батлах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 25/01, 25/02 тоот тогтоолууд
 4. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан
 5. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2024 оны санхүүгийн хураангуй тайлан, аудитын дүгнэлт
 6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийн санал
- **Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж буй нэр дэвшигчдийн танилцуулга**
- **Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төслүүд**
- **“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын санал авах хуудас**
- **Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах газрын мэдээлэл**

ЭРХЭМ ХҮНДЭТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЭ,

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагын баг болон нийт хамт олны зүгээс Хувьцаа эзэмшигч та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Бид 2024 онд бид бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан барьцаагүй, 100% дижитал бизнесийн бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлж, олон мянган бизнес эрхлэгчдийг цаг хугацаа, хөрөнгө, бичиг баримтын ачааллаас чөлөөлсөн санхүүгийн салбар дахь шинэ үеийг эхлүүлээд байна.

Манай энэхүү дижитал бизнесийн бүтээгдэхүүн нь нийгэмд үнэ цэнтэй, шинэлэг шийдэл болсон гэдгийг олон улсын түвшинд ч хүлээн зөвшөөрсөн юм. Тодруулбал, Сингапурын Төв Банк болон Финтек Холбооноос зохион байгуулдаг “Fintech Excellence Awards” арга хэмжээний “Financial Inclusivity” төрөлд эцсийн шатанд шалгарч, Зүүн Өмнөд Ази болон олон улсын хэмжээнд жижиг, дунд бизнесийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан гэж үнэлэгдсэн нь бидний хувьд томоохон амжилт байлаа.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хурлаас компанийн 2024 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 15 (арван таван) төгрөг буюу нийт 11,089,525,245 (арван нэгэн тэрбум наян есөн сая таван зуун хорин таван мянга хоёр зуун дөчин тав) төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэлээ. Ногдол ашгийг 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгох юм.

Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс ногдол ашиг авах эрхтэй компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр байхаар тогтоолоо.

2025 онд бид эдийн засгийн өсөлтийг хурдасгах, бизнес эрхлэлтийг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд манлайлан оролцох зорилгоо үргэлжлүүлэн ажиллах болно.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн энэ удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 12 цагт Галлериа Улаанбаатар төв (Gallery Ulaanbaatar Center)-ийн 3 давхарт байрлах Juulchin Ballroom танхимд болох болно.

Технологиор дамжуулан бүгдэд нээлттэй, гэгээлэг маргаашийг хамтдаа бүтээх зорилготой бидний үйл ажиллагааг үргэлж дэмжиж байдаг хувьцаа эзэмшигчид, эрхэм түншүүд, үнэнч харилцагч та бүхэндээ талархлаа илэрхийлье.

“ЛэндМН ББСБ” ХК

Хурлаар хэлэлцэх асуудал

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
3. Компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;
4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох;
5. Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах;
6. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах
1 Хурлын ирц бүртгэх	11:00-12:00	Тооллогын комисс
2 Хурлын ирцийг мэдээлэх	12:00-12:05	Тооллогын комиссын дарга
3 Хурлыг нээх, хурлын дэг танилцуулах	12:05-12:10	Хурлын дарга
4 Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах	12:10-12:20	Гүйцэтгэх захирал
5 Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх	12:20-12:25	Хурлын дарга
6 Компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах	12:25-12:40	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
7 Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах	12:40-12:50	Хурлын дарга
8 Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийн саналыг танилцуулах	12:50-13:00	Гүйцэтгэх захирал
9 Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг танилцуулах	13:00-13:10	Гүйцэтгэх захирал
10 Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт	13:10-13:30	Хурлын дарга, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн хараат бус гишүүд
11 Хэлэлцэж байгаа асуудлуудаар санал хураах	13:30-13:50	Хурлын дарга, Тооллогын комиссын дарга
12 Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах	13:50-14:20	Тооллогын комиссын дарга
13 Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг тусган, танилцуулж, батлуулах	14:20-14:30	Хурлын дарга

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Баримт бичгийн жагсаалт

- 1 “ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 25/07 тоот тогтоол;
- 2 Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар;
- 3 Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
- 4 “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан;
- 5 “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2024 оны санхүүгийн аудитлагдсан тайлан;
- 6 “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан;
- 7 “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн танилцуулга;
- 8 “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийн санал;
- 9 “ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл;
- 10 “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх дүгнэлт батлах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 25/01, 25/02 тоот тогтоолууд;
- 11 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл;
- 12 Хувьцаа эзэмшигчдийн хурлын нэмэлт материал;
- 13 Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудас.

**ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар
сарын 06-ны өдрийн 25/07
ТООТ ТОГТООЛ**

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 25/07

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх хэсэг, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2 дугаар бүлгийн 2.1, 2.3, 2.5 дахь хэсэг, 3 дугаар бүлэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 болон 8.2 дахь хэсэг болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Компанийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 12:00 цагт Галлериа Улаанбаатар төв (Gallery Ulaanbaatar Center)-ийн 3 давхарт байрлах Juulchin Ballroom танхимд зохион байгуулахаар шийдвэрлэсүгэй.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай:
 - Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
 - Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - Компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;
 - Компанийн ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох;
 - Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах;
 - Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөр тогтоосугай.
- Компанийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг энэхүү тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталж, “Санхүүгийн зохицуулах хороо” болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн дотор хүргүүлэхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д үүрэг болгосугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зарыг энэхүү тогтоолын Хавсралт №2-ын дагуу баталж, 2025 оны 02 дугаар сарын 10 болон 26-ны өдрүүдэд Компанийн цахим хуудас, өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз, мэдээллийн цахим хуудас болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг энэхүү тогтоолын

Хавсралт №3-ын дагуу баталж, баримт бичгийг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор бэлтгэн, хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хүргүүлж танилцах бололцоогоор хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

- Хувьцаа эзэмшигч нь энэхүү тогтоолын Хавсралт №3-т заасан баримт бичгийг 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр хүртэл Компанийн <https://lend.mn/> вэбсайт болон Компанийн байранд биечлэн ирж танилцаж болохыг мэдэгдсүгэй.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Компанийн ТУЗ-ийн дарга (О.Болдбаатар)-ыг томилсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийг Компанийн дараах ажилтнуудын бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

М.Түвшинжаргал Санхүү, үйл ажиллагааны газрын захирал

Гишүүд:

Б.Оюунболд	ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга
Ц.Хулан	Хууль, хяналт нийцүүлэлтийн мэргэжилтэн
Г.Гэрэл	Санхүүгийн шинжээч
Б.Батбилэг	Маркетингийн хэлтсийн менежер
Н.Янжиндолгор	Маркетингийн менежер
Н.Эрхэмбаяр	Ахлах график дизайнер
Э.Гүндалай	График дизайнер
Э.Эрэлхэгзориг	Мэдээлэл технологийн хэлтсийн захирал
Г.Гэрэлтнاران	Мэдээллийн аюулгүй байдлын ажилтан
Т.Гэрэлмаа	Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн албаны менежер
Э.Хулан	Хүний нөөцийн мэргэжилтэн
Ц.Сайханцэцэг	Оффис менежер
Ц.Оюунбаяр	Хэрэг бүртгэлийн менежер
Б.Сансартуяа	Харилцагчийн халамжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дарга, гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

С.Батбуян “ЭмДиЭс Хаан Лекс” ХХН, Партнерс

Гишүүд:

Х.Хулан	Хуулийн мэргэжилтэн
Э.Билгүүн	Ахлах нягтлан бодогч
Д.Шүрэнцэцэг	Санхүүгийн шинжээч

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс саналын хуудасны дагуу санал авч, түүнийг үндэслэн хурлын тогтоолыг гаргахыг Хурлын дарга (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг энэхүү тогтоолын Хавсралт №4-ийн дагуу, санал авах хуудсыг Хавсралт №5а, №5б-ын дагуу тус тус баталсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудсыг брокер, дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт санал авах ажлыг зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисст үүрэг болгож, тэдгээр саналыг хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 18:00 цагаар тасалбар болгохоор тогтоосугай.
14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахтай холбогдон гарах зардлын төсвийг баталж, санхүүжүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д зөвшөөрсүгэй.
15. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд), Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.



**ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар
сарын 06-ны өдрийн 25/03
ТООТ ТОГТООЛ**

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 25/03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 23 дугаар зүйл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн Үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.8.8 дахь заалт, Компанийн Ногдол ашгийн бодлогын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг болон Компанийн ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 15 (арван таван) төгрөгөөр тогтоож, 2024 оны цэвэр ашгийн 30.62 (гуч зууны жаран хоёр) хувийг буюу 11,089,525,245 (арван нэгэн тэрбум наян есөн сая таван зуун хорин таван мянга хоёр зуун дөчин тав) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар суутган тооцож, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн лотор олгосугай.
4. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, ногдол ашгийг холбогдох хууль тогтоомж, энэхүү тогтоолд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгохыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 25/01, 25/02 тоот тогтоолууд

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 25/01

Улаанбаатар хот

**Компанийн 2024 оны санхүүгийн
тайлангийн талаар
дүгнэлт гаргах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 80 дугаар зүйл, 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.16 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн АХ-25/01 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон, СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн Компанийн нэгтгэсэн санхүүгийн тайланд холбогдох хууль тогтоомжийн дагуу хөндлөнгийн аудит хийж, гаргасан хараат бус аудиторын дүгнэлтийг хүлээн зовшоорсугэй.
2. Энэхүү тогтоолын 1-г заасан тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих эрх бүхий байгууллагуудад хүргүүлж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолын 1-г заасан тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, зохих шийдвэрийг гаргуулахыг ТУЗ-ийн Дарга (О.Болдбаатар)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга (Ж.Жаргалсүрэн)-д үүрэг болгосугай.

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 25/02

Улаанбаатар хот

**Компанийн 2024 оны үйл ажиллагааны
тайлангийн талаар
дүгнэлт батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.16 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, зохих шийдвэрийг гаргуулахыг ТУЗ-ийн Дарга (О.Болдбаатар)-д даалгасугай.



"ЛэндМН ББСБ" ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан

"ЛэндМН ББСБ" ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн агуулга

✓ Бизнесийн үйл ажиллагаа

- Үйл ажиллагааны хураангуй
- Дижитал бизнесийн зээлийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө
- Компанийн онцлох үйл явдал
- Зээлийн үйл ажиллагаа
- Хүний нөөц


✓ Эрсдэлийн удирдлага

- Эрсдэлийн удирдлага

✓ Компанийн засаглал

- Компанийн ерөнхий мэдээлэл
- Компанийн засаглал
- "Компанийн засаглалын кодекс"-ын хэрэгжилт, түүний үнэлгээ
- Хувьцаа эзэмшигчдийн хурал
- Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
- ТУЗ-ийн хурал, үйл ажиллагаа
- Дотоод аудит
- Удирдлагын баг
- Компанийн бүтэц, зохион байгуулалт
- Хувьцааны мэдээлэл
- Ногдол ашгийн мэдээлэл

2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ



Бизнесийн үйл ажиллагаа

- ✓ Үйл ажиллагааны хураангуй
- ✓ Дижитал бизнесийн зээлийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө
- ✓ Компанийн онцлох үйл явдал
- ✓ Зээлийн үйл ажиллагаа
- ✓ Хүний нөөц

БИЗНЕСИЙН ЗЭЭЛИЙГ ШИНЭ ТҮВШИНД ГАРГАВ

Бизнесийн орчин хурдтай өөрчлөгдөж буй энэ цаг үед эргэлтийн хөрөнгийн санхүүжилтээ шийдэхийн тулд банк, санхүүгийн байгууллагаар олон хоног явж, бичиг баримт бүрдүүлдэг үе түүх болжээ.

ЛэндМН нь Монголдоо анх удаа технологийн шийдлийг ашиглан нэмэлт бичиг баримт, **Барьцаа хөрөнгө шаардахгүйгээр** ердөө **5 минутын дотор** бизнесийн зээлийг дансандаа хүлээн авах "Flexi business" хэмээх цоо шинэ санхүүгийн бүтээгдэхүүнийг үйлчилгээндээ нэвтрүүллээ.

Тус бүтээгдэхүүнийг үйлчилгээнд нэвтрүүлэхдээ бид бизнес эрхлэгч нарт тулгардаг хамгийн түгээмэл асуудлууд болох барьцаа хөрөнгө, зээл авахад зориулж буй цаг хугацааг хэмнэх дээр төвлөрч, өөрсдийн 8 жилийн хугацаанд цуглуулсан кредит скоринг ноу-хау, технологийн шийдлийг ашиглан бүтээгдэхүүнээ хөгжүүлж, нийт харилцагч нартаа 2024 оны 03 дугаар сард анхлан танилцуулсан.

"Flexi business" зээлийн бүтээгдэхүүнийг танилцуулж эхэлснээс хойш 10 сар гаруй

хугацаанд давхардсан тоогоор нийт **123 мянган бизнес эрхлэгч** LendMN аппликейшнээр зээлийн эрхээ хэдийн тооцуулсан бөгөөд **35 мянган удаагийн олголтоор** нийт **153 тэрбум төгрөгийн бизнесийн зээл** олгоод байна. 2024 оны эцсийн байдлаар нийт зээлийн багцын **23% нь тус бизнесийн зээлийн багцаас бүрдэж байна.**

"Flexi business" зээлийн бүтээгдэхүүнийг ашиглаж буй харилцагч нар маань худалдаа үйлчилгээний салбарт бизнес эрхэлж буй иргэд байдаг бөгөөд үүний **65% нь эмэгтэй бизнес эрхлэгчид**, түүнд ногдох зээлийн багц нь **нийт бизнесийн зээлийн багцын 66%-ийг эзэлж байна.**

Техник технологийн хөгжлийг даган санхүүгийн үйлчилгээ шинэ түвшинд гарах хэрэгцээ шаардлага үүсэж байна. Үүнтэй зэрэгцэн ЛэндМН-ийн баг хамт олон бизнес эрхлэгчид тэр дундаа жижиг, дунд бизнес эрхлэгчдийнхээ санхүүгийн хэрэгцээнд нийцсэн, нийгэмдээ үнэ цэнийг бий болгох бүтээгдэхүүн үйлчилгээг санаачлан нэвтрүүлсээр байна.



Flexi business зээлийн бүтээгдэхүүнээрээ дамжуулан бид нийгэмд дараах эерэг өөрчлөлтийг авчрахаар зорьж байна.

- ✓ **Санхүүгийн хүртээмжийг тэлэх:** Бизнесийн зээлийг барьцаагүй, дигиталаар авах боломжийг нэвтрүүлсэнээр зээлийн санхүүжилт авч чадахгүй байсан олон бизнес эрхлэгчид санхүүжилт авах боломжтой болно.
- ✓ **Эмэгтэйчүүдийн бизнес эрхлэх боломжийг нэмэгдүүлэх:** Худалдаа үйлчилгээний бизнес эрхэлж байгаа бүсгүйчүүд маань санхүүжилт авч өөрсдийн бизнесийг өргөжүүлсэнээр тэдний гэр бүл, нийгэмдээ эзлэх байр суурь сайжирна.

✓ **Санхүүгийн тогтолцооны эерэг өөрчлөлтийг бий болгох:** Технологид суурилсан зээлийн шийдэл нь хүний хүчин зүйлийг багасгаж, илүү шударга, ил тод санхүүгийн тогтолцоог бүрдүүлэхэд гол нөлөө үзүүлнэ.

"ЛэндМН ББСБ" ХК нь бизнес эрхлэгчдэд бодит эерэг өөрчлөлтийг авчрахын төлөө ажиллаж байгаа бөгөөд LendMN аппликейшнээр дамжуулан "Flexi business" зээлийн бүтээгдэхүүнийг ашиглаж өөрийн бизнесийг өргөжүүлэн тэлж байгаа харилцагчдаа харахад бид туйлын их баяртай байна.



2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

✓ “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2024 онд танилцуулсан 100% дижитал, бизнесийн барьцаагүй зээлийн үйлчилгээ “Flexi Business” бүтээгдэхүүн нь Сингапурын Төв Банк болон Сингапурын Финтек Холбооноос хамтран олгодог “Fintech Excellence Awards”-ийн Financial Inclusivity төрөлд нэр дэвшиж, Зүүн Өмнөд Ази цаашлаад олон улсын жижиг дунд бизнесийн санхүүгийн хүртээмжийг сайжруулахад өндөр хувь нэмэр оруулсан гэж хүлээн зөвшөөрөгдөж, эцсийн шатанд шалгарсан. Энэ нь Дижитал бизнесийн зээлийг Монголдоо төдийгүй Зүүн Өмнөд Азидаа анх удаа нэвтрүүлснийг үнэлсэн чухал үйл явдал боллоо.



✓ “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 02 сарын 05-ны өдрийн 24/03 тогтоолоор нэгж хувьцаанд 8 төгрөг буюу Компанийн 2023 оны цэвэр ашгийн 29.9%, нийт 5,914,413,464 төгрөгийн ногдол ашгийг олгохоор шийдвэрлэсний дагуу 2024 оны 04 сарын 05-ны өдөр “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-аар дамжуулан нийт 7,744 хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг үнэт цаасны дансанд байршууллаа.



✓ Тайланд улсын Бангкок хотноо зохион байгуулагдсан “Making Sense of AI in Asia” форум болон AmCham Mongolia-аас зохион байгуулсан May Monthly Meeting “AI Unleashed: Revolutionizing Businesses” хэлэлцүүлэгт ЛэндМН-ийн Дэд захирал Д.Баасандорж оролцож, Монголын анхны финтек компани болох ЛэндМН нь хиймэл оюун ухаан дээр суурилан Монголд төдийгүй Зүүн Өмнөд Азидаа анх удаа 100% дижитал бизнесийн зээл гаргасан туршлагаасаа хуваалцаж, амжилттай оролцлоо.



✓ “ЛэндМН ББСБ” ХК нь МҮЦАЭХ болон “Санхүүгийн Зохицуулах Хороо”-ны зөвшөөрлөөр Биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд 2 удаагийн нийт 20 тэрбум төгрөгийн бондыг гарган амжилттай татан төвлөрүүллээ.



✓ “Монголын Финтекийн Холбоо”-оос зохион байгуулдаг “Frontier Fintech Summit 2024”-ийн илтгэгч LendMN-ийн Дэд захирал Д.Баасандорж энэ удаагийн арга хэмжээнд “Empowering MSMEs: The Future of Fintech Lending for Growth and Innovation” сэдвийн дор өөрийн илтгэлийг танилцууллаа.




✓ 2024 оны 3-р улиралд бид LendMN аппликейшнээ шинэчилснээр харилцагчийн нууцлал аюулгүй байдлыг сайжруулан, илүү олон боломжуудыг багтаасан финтек зээлийн үйлчилгээг LendMN 2.0 аппликейшнээр үзүүлж эхэллээ. Энэхүү өөрчлөлтөөр:

- Харилцагч бүртгэхэд илүү хялбар болов.
- Нийгмийн даатгалын мэдээлэлд үндэслэн зээлийн эрх тооцоолдог болов.
- Бүхтөрлийн лавлагаа, тодорхойлолтыг аппликейшнээс авдаг болов.





✓ “Plus” хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнээ харилцагч нарынхаа хэрэгцээнд тулгуурлан уян хатан нөхцөлтэйгөөр шинэчиллээ. Ингэснээр бид харилцагч нарынхаа санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, өөртөө хөрөнгө оруулалтын зөв дадлыг бий болгоход ихээхэн хувь нэмэр үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.



ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 онд нийт харилцагч нартаа 1 их наяд төгрөгийн дүнтэй 2 сая зээлийг LendMN аппликейшнээр дамжуулан олгосон байна. 2024 онд бүртгэлтэй харилцагчдын тоо 1.3 саяд хүрч өмнөх оноос 10%-иар өссөн бол, зээлийн багц

90% өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү ЛэндМН-ийн зээлийн үйл ажиллагааны өсөлт нь харилцагчдын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээгээр ханган ажиллаж байгааг илтгэж байна.




Зээлийн багцын чанарын үзүүлэлт

2024 онд чанаргүй зээл нийт зээлийн багцад эзлэх хувийг 4.3%-д барьж ажилласан нь салбарын дундаж чанаргүй зээлийн хувь хэмжээнээс бага түвшинд байна. Бид зээлийн багцын чанарыг сайжруулахад цаг үетэйгээ уялдсан шийдвэрүүдийг шуурхай гаргаж, анхаарч ажиллалаа.

СТОУС-9 (IFRS-9)-ын стандартын дагуу 13.2 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн

нөөц санг байгуулсан ба энэ нь Санхүүгийн Зохицуулах Хорооны журамд заасан шаардлага хангах дүнг 2 дахин давуулан биелүүлж, зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээг 129%-д хүргэж ажиллалаа.

Зээлийн эрсдэлийн санг байгуулахдаа болзошгүй эрсдэлүүдийг тооцоолсноор компанийн эрсдэл даах чадварыг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг ханган ажиллаж байна.



ХҮНИЙ НӨӨЦ

2024 онд эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран нийт ажилтнуудын цалинг нэмэгдүүлж ажиллалаа. Хагас жил тутамд гүйцэтгэлээс хамаарсан урамшууллыг бүх ажилтнуудад олгож байна.

.02 ЦАЛИН, УРАМШУУЛАЛ:



.03 АЖИЛЛАХ ТААТАЙ ОРЧИН, НӨХЦӨЛ:


Ажилтнуудын ая тухтай, чөлөөтэй сэтгэх орчныг бүрдүүлж эко ногоон орчин бүхий УБ хотын хамгийн таатай оффист ажиллаж эхэллээ.

.01 ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО:

Хүний нөөцийн бодлогыг сайжруулах төлөвлөгөө гарган гаднын улс орны жишигтэй харьцуулан судалж, гадаад мэргэжилтэнтэй хамтран боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Цаашид хүний нөөцийн бодлогодоо ажилтан бүрийн санал, хүсэлтийг тусган сайжруулан ажиллах болно.

.04 АЖИЛТНУУДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

Мэргэжлийн байгууллагаар Компанийн талаарх ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авч ажиллаж байгаа бөгөөд өмнөх оноос сэтгэл ханамжийн түвшин 2.4 хувь өссөн үзүүлэлттэй гарсан нь ажилтнууд компанидаа ажиллахдаа сэтгэл хангалуун байгааг илтгэж байна.



.05 СУРГАЛТ, ХӨГЖҮҮЛЭЛТ, ЧАДАВХ БҮРДҮҮЛЭЛТ:

"Мэдлэгээ асаая" сургалт, хөгжлийн бодлогын хүрээнд гадаад, дотоод болон мэргэжлийн байгууллагын сургалтад ажилтнуудыг хамруулж, мэргэшсэн ажилтны тоог нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

.06 ЭРҮҮЛ МЭНД, САЙН САЙХАН БАЙДАЛ, АЖИЛ АМЬДРАЛЫН ТЭНЦВЭРИЙН ХАНГАХ БОДЛОГО:

Нийт ажилтнуудыг болон тэдгээрийн гэр бүлийг эрүүл мэндийн даатгалд хамруулан, өөрийн хүссэн эмнэлгээс эрүүл мэндийн багц үйлчилгээг тогтмол авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Жил бүр ажилтнуудыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан ажиллаж байна.



Өглөөний цай:

Ажилтнуудынхаа эрүүл мэндэд тохирсон өглөөний цай хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Спорт заал:


Ажилтнуудын чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэхэд зориулж спорт зааланд тоглох боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Уян хатан цагийн нөхцөл:

Ажлын байрны уян хатан цагийн менежментийг бий болгож, ажлын цагийг сонголттойгоор сонгон ажиллах боломжийг ажилтнууддаа бүрдүүлэн үр дүнтэй хэрэгжиж байна.



**ЦАХИМ ЗАЛИЛАНГААС
ХАМТДАА СЭРГИЙЛЪЕ.**



Эрсдэлийн удирдлага

✓ Эрсдэлийн удирдлага

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

“ЛэндМН ББСБ” ХК нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, харилцагчид болон хамтран ажиллагч нарынхаа итгэлийг хүлээж бизнесийн ёс зүйг эрхэмлэн ажиллаж, сайн засаглалын хүрээнд Эрсдэлийн Удирдлагын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж ажилласаар ирлээ.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан Эрсдэлийн удирдлагын бодлогоор “Хамгаалалтын гурван шугамын загвар”-ыг тодорхойлон компанийн бүх нэгжүүдийн чиг үүрэг, төлөвлөгөө, гүйцэтгэлийн үнэлгээг уялдуулан ажиллаж байна.

I шугам	II шугам	III шугам
Компанийн бодлого, журам болон өөрсдийн чиг үүргийн хүрээнд өдөр тутмын бизнесийн үйл ажиллагааны эрсдэлийг хариуцан ажилладаг бизнес нэгжүүд болон тэдгээрийг дэмжих чиг үүрэгтэй нэгжүүд	“Нэгдүгээр шугам”-д хамаарах нэгжүүдийн эрсдэлээ хэрхэн удирдаж байгаад хяналт тавих, компанийн хэмжээнд ямар хэмжээний эрсдэл хүлээж байгааг хянах, хязгаарлах чиг үүрэгтэй нэгжүүд	Хараат бус дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж

Эрсдэл хариуцсан нэгж нь Финтек зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл, харилцагчаас хамаарч үүсэх эрсдэлийг тус тус үнэлж түүнийг бууруулах зөвлөмж хүргүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан үе шаттайгаар тогтмол хэрэгжүүлэн ажилласан.

“Зээлийн эрсдэлийн удирдлага”

Зээлийн эрсдэл гэдэг нь зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас ББСБ алдагдал хүлээх магадлалыг хэлнэ. “ЛэндМН ББСБ” ХК нь зээлийн эрсдэлийн удирдлага нь эрсдэлийн тодорхой орчин нөхцөлд тохируулан эрсдэлийн нөлөөллийг удирдах замаар компанийн ашигт ажиллагаа, өгөөжийг хамгийн өндөр түвшинд байлгахад чиглэдэг.

“Комплаенсийн эрсдэл”


Комплаенсийн эрсдэлийн удирдлагын хүрээнд үндсэн 2 чиг үүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулсан. Үүнд:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд, хүлээсэн үүргээ биелүүлж компанийн дотоод хяналтын хөтөлбөрөөр дамжуулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх,
- Монгол улсын хэмжээнд шинэчлэгдсэн, нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагын дүрэм журамд орсон өөрчлөлтийг тухай бүр өөрийн компанийн дотоод бодлого, журамд нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг үйл ажиллагаандаа нийцүүлэн ажиллаа.

ЛэндМН-ийн голлох эрсдэлүүд

Гол эрсдэлүүд	Эрсдэлийн үйл явдал, үр дагавар, нөлөөлөл	Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт
Зах зээлийн эрсдэл	- Гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс санхүүгийн алдагдал хүлээх. - Эх үүсвэр болон активын хүүгийн зөрүүгээс санхүүгийн алдагдал хүлээх.	- Гадаад валютын нээлттэй позициг зохистой түвшинд барин ажиллав. - Эх үүсвэр, активын удирдлагыг оновчтой хэрэгжүүлсэн. - Гадаад валют, үнэт цаасны ханшийн хэлбэлзлийг тооцон ажиллав.
Санхүүгийн эрсдэл	- Зохистой харьцааны үзүүлэлт алдагдах. - Төлбөрийн чадвар алдагдах буюу хөрөнгө оруулагчийн мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар буцаан төлөх боломжгүй болох. - Зээлийн эрэлт, өсөлтийг хангахгүй болох. - Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа үзүүлэлт алдагдах.	- Төлөвлөлт хангалттай хэрэгжүүлсэн. - Тогтмол тайлагналт хийж байв. - Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн. - Эх үүсвэрийн төвлөрлийг удирдсан. - Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулсан бодлого чиглэл баримталж ажиллаа.
Зээлийн эрсдэл	- Зээлийн багцын чанар буурах. - Зээл төлөгдөхгүй байх магадлал (PD) болон зээлийн алдагдал үүсэх (LGD) магадлал нэмэгдэх. - Зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн хэмжээ өсөх.	- Компанийн дотоод бодлого, журам, бүтээгдэхүүний нөхцөлийг шинэчлэн баталлаа. - Зээлийн скоринг, зээлдэгчийн үнэлгээний загвар, аргачлалыг дахин шинэчлэв.
Үйл ажиллагааны эрсдэл	- Биет эд хөрөнгийн зардал гарах, - Бизнесийн үйл ажиллагааны тасалдал үүсэх, - Санхүүгийн хохирол (мөнгөн алдагдал) гарах, - Санхүүгийн бус хохирол (мөнгөн дүнгээр хэмжих боломжгүй нэр хүндийн гм) гарах.	- Дотоод бодлого, журам, зааврыг шинэчлэв. - Дотоод хяналтын хэрэгжилтийг ханган ажиллалаа. - Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц гадаад, дотоод эрсдэлийг үнэлж, эрсдэлийн магадлалыг бууруулах төлөвлөгөөг гарган, хэрэгжүүлж, тайлагнаж ажиллаа.
Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл	- Мэдээлэл алдагдах, түүнийг бууруугаар ашиглах. - Мэдээллийн бааз гэмтэх, устах. мэдээлэлд хандах боломжгүй болох. - Системийн эмзэг байдлыг ашиглах.	- ISO 27001:2013 мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартыг 3 дахь жилдээ хэрэгжүүлж, олон улсын байгууллагаар сертификатаа баталгаажууллаа. - Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлж, түүнтэй холбоотой журмуудыг шинэчлэн баталлаа. - Системийн эмзэг байдал, цахим халдлага зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлж тогтмол аюулгүй байдлын тест явуулж, тасралтгүй сайжруулалтыг хийж ажиллаа.
Байгаль орчин, нийгмийн хариуцлага	- Байгаль орчинд хохиролтой үйл ажиллагааг санхүүжүүлэх - Нийгмийн хариуцлагын үйл ажиллагааг шийдвэр гаргалтад чухалчилж үзэхгүй байх	- Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргахдаа хууль, хянан нийцүүлэлт болон байгаль орчин нийгэмд эрсдэлтэй эсэхийг харгалзан үзэж шийдвэр гаргадаг. - Иргэд болон худалдаа, үйлчилгээний бизнес эрхлэгч нарт зээлийн үйлчилгээ үзүүлдэг тул байгальд хор хөнөөлтэй үйл ажиллагааг дэмждэггүй. - Нийгмийн хариуцлагын хүрээнд, олон компани ажлуудаас гадна санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд ажиллаж байна.

Монголын хамгийн анхны финтек компани



Компанийн засаглал

- ✓ Компанийн ерөнхий мэдээлэл
- ✓ Компанийн засаглал
- ✓ "Компанийн засаглалын кодекс"-ын хэрэгжилт, түүний үнэлгээ
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн хурал
- ✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
- ✓ ТУЗ-ийн хурал, үйл ажиллагаа
- ✓ Дотоод аудит
- ✓ Удирдлагын баг
- ✓ Компанийн бүтэц, зохион байгуулалт
- ✓ Хувьцааны мэдээлэл
- ✓ Ногдол ашгийн мэдээлэл

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр: "ЛэндМН ББСБ"	МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал: I ангилал
Хэлбэр: Нээлттэй хувьцаат компани	Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг: 800,000,000
Регистрийн дугаар: 5039754	Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо: 8,576 (давхардсан тоогоор) <i>2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар</i>
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага: Монголын хөрөнгийн бирж	Үндсэн үйл ажиллагааны чиглэл: 1. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх 2. Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах 3. Зээл олгох үйл ажиллагаа 4. Факторингийн үйлчилгээ 5. Итгэлцлийн үйлчилгээ 6. Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

"ЛэндМН ББСБ" ХК нь Монгол Улсын хуультогтоомжболон Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй, нээлттэй хувьцаат компани болохынхоо хувьд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, түүнчлэн Монголбанкны холбогдох журам, засаглалын дүрэм, кодексыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

"ЛэндМН ББСБ" ХК (цаашид "Компани") нь зохистой засаглал, засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангахад онцгойлон анхаарч, улмаар удирдлагын баг, төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцааг төгөлдөржүүлэх, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн

урт хугацаанд тогтвортой үнэ цэнийг бий болгохыг үргэлж зорьсоор ирсэн юм.

Манай Компани нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, оролцогч талуудтай үр дүнтэй холбоо үүсгэх, санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөв, цаг алдалгүй хүргэх зорилгоор үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн талаар улирал бүрийг болон хагас жилийн хугацааг хамруулан мэдээлэх стратегийг баримталж, нийт 3 удаагийн тайлан гарган олон нийтэд хүргээд байна.

Ийнхүү 2024 оны I улирлын тайланг 2024 оны 04 дугаар сарын 15-ны өдөр, II улирал буюу хагас жилийн тайланг 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдөр, III улирлын тайланг 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр тус тус гарган олон нийтэд мэдээлснээр Компанийн бизнес, засаглал,

санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийн талаарх мэдээллийг тухай бүр авах боломжийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, харилцагчид болон оролцогч талуудад олгож, харилцан итгэлцэл, эргэх холбоо бүхий хамтын ажиллагааг бий

болгосон юм.

Түүнчлэн, Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллалаа.

"КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ЫН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ыг үйл ажиллагаандаа даган мөрдөж, 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 93%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна.

Түүнчлэн, "Компанийн засаглалын кодекс" нь тасралтгүй хэрэгжиж, үйл ажиллагааны онцлогоос хамаарч үнэлгээ нь тухай бүр шинэчлэгддэг онцлогтой тул Компанийн зүгээс 100%-ийн гүйцэтгэлээ хангахын тулд хүчин зүтгэлээ гарган ажиллах болно.

Үндсэн зарчим	Авбал зохих нийт оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10	83.3%
ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9	90%
Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	5	83.3%
Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
Эрсдэлийн удирдлага	8	8	100%
Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%
Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
Компанийн соёл	6	6	100%
Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	90%
Нэгдсэн дүн	72	67	93%

Хувьцаа эзэмшигчид

АНД Системс ХХК	600,000,000
Олон нийт	139,301,683
Халаасны хувьцаа	60,698,317

Хувьцаа эзэмшигчдийн хурал

“ЛэндМН ББСБ” ХК нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн өнөөдрийг хүртэл санхүү, хөрөнгийн зах зээлд шинийг санаачлагч, манлайлагч байсаар ирсэн уламжлалаа хадгалан компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “ХЭЭХ”)-ыг тасалдуулахгүй зохион байгуулан ажилласан билээ.

Компанийн зүгээс Монгол улсын Компанийн тухай хуульд заасны дагуу 2023 оны ХЭЭХ-ыг 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдөр “БЭСТ ВЭСТЭРН ПРИМЬЕР Туушин зочид буудал”-ын Соёмбо танхимд хийлээ. ЛэндМН нь 7 дахь удаагаа амжилттай зохион байгуулсан ба нийт саналын эрх бүхий хувьцааны 81.7% буюу 603,983,333 ширхэг хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсоноор тус хурал хүчин төгөлдөр болсон ба дараах асуудлыг хэлэлцэн баталсан юм. Үүнд

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсвийг батлах;
- Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.

Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн бүрэлдэхүүн



О.Болдбаатар
 “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх хорооны гишүүн
 “АНД Глобал” Пти.Лтд, ТУЗ-ийн гишүүн
 “ОНДО Холдинг” ХХК, ТУЗ-ийн гишүүн



Ц.Ууганбаяр
 “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн
 “АНД Глобал” Пти.Лтд-ийн Санхүү эрхэлсэн захирал
 “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал



Б.Хос-Эрдэнэ
 “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн
 “АНД Глобал” Пти.Лтд-ийн Гүйцэтгэх захирал
 “АНД Системс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал



К. Мадано
 “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн
 “AND Financing Corporation”, Ерөнхийлөгч / Гүйцэтгэх захирал
 “ЛэндМН ББСБ” ХК, Ерөнхийлөгч



Ц. Одмаа
 “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн, Цалин, урамшууллын хорооны гишүүн
 Мэргэжил: Хуульч, өмгөөлөгч
 “ОНДО Холдинг” ХХК, Хуулийн газрын захирал



С.Энх-Амгалан
 “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн
 “Мэргэн Инвестмент” Пти.Лтд, ТУЗ-ийн гишүүн
 “Монложистикс Холдинг” ХК, ТУЗ-ийн гишүүн



Ж. Жаргалсүрэн
 “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Засаглал, нэр дэвшүүлэх хорооны гишүүн
 “Бейкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Удирдлагын партнер/ Гүйцэтгэх захирал



С.Боргил
 “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх хорооны дарга, Аудитын хорооны гишүүн, Цалин, урамшууллын хорооны гишүүн
 “Сэргэлт Консалтинг групп”-ийн Гүйцэтгэх захирал



С. Нэргүй
 “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, Цалин, урамшууллын хорооны дарга
 “Сургалт үнэлгээ судалгааны хүрээлэн” НҮТББ, Захирал, Ахлах зөвлөх

ТУЗ-ийн хурал, үйл ажиллагаа

ТУЗ нь Компанийн үйл ажиллагааг бэхжүүлэх, зохистой түвшинд удирдах, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг хэрэгжүүлэх, стратегийн зорилтдоо хүрэхэд Компанийг ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихын зэрэгцээ Гүйцэтгэх удирдлагад компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

Компанийн ТУЗ нь ердийн 6, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өнгөрсөн нэг жилийн хугацаанд 5 удаа ээлжит, 1 удаа ээлжит

бусаар хуралдан нийт 43 тогтоол гаргажээ. ТУЗ-ийн бүхий л тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлээд байна.

ТУЗ-ийн эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг, байнгын ажиллагаа бүхий 1/ Эрсдэлийн удирдлагын хороо, 2/ Аудитын хороо, 3/ Засаглал, нэр дэвшүүлэх хороо, 4/ Цалин, урамшууллын хороод үйл ажиллагаа явуулж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

Эрсдэлийн удирдлагын хороо (цаашид "ЭУХ") Аудитын хороо

Бүрэлдэхүүн

С.Нэргүй (Хорооны дарга)
Б.Хос-Эрдэнэ, Ц.Ууганбаяр,
Кацухико Мадоно, С.Энх-Амгалан

Ж.Жаргалсүрэн (Хорооны дарга)
Ц.Одмаа
С.Боргил

ЭУХ нь тайлант жилийн хугацаанд нийт 4 удаа хуралдаж, Компанийн бизнесийн хөгжил, эрсдэл болон эх үүсвэрийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг оновчтой удирдан чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нөхцөл байдалтай тухай бүр танилцан хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 4 удаа хуралдаж, Компанийн дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудиторын үйл ажиллагааны тайлантай тухай бүр танилцан шаардлагатай санал, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд болон Компанийн газар, албадад өгч ажиллалаа. Түүнчлэн, Компанийн зүгээс хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргах, Компанийн санхүүгийн тайланг баталгаажуулах хөндлөнгийн аудитын байгууллагыг томилох, Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байлгахад анхаарч мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэж буй эсэхэд хяналт тавьж ажилласан байна.

Засаглал, нэр дэвшүүлэх хороо (цаашид "ЗНДХ") Цалин, урамшууллын хороо (цаашид "ЦУХ")

Бүрэлдэхүүн

С.Боргил (Хорооны дарга)
О.Болдбаатар
Ж.Жаргалсүрэн

С.Нэргүй (Хорооны дарга)
Ц.Одмаа
С.Боргил

ЗНДХ нь тайлант жилийн хугацаанд нийт 1 удаа хуралдаж, ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг шинээр сонгох асуудлыг хэлэлцэн Компанийн ХЭЭХ-д танилцуулан шийдвэрлүүлэх тухай шийдвэрлэж, мөн Компанийн мөрдөж буй ажлын үр дүнтэй холбоотой урамшууллын системийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгч, гүйцэтгэх захирлын томилгоо, гүйцэтгэх захирлын урамшуулалтай холбоотой дүгнэлт гарган ажилласан байна.

ЦУХ нь ТУЗ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 24/17 дугаартай "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор байгуулагдсан бөгөөд Компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих, ажиллагсдын тэтгэврийн даатгалын болон хувьцаа эзэмшүүлэх аливаа хөтөлбөрийг судалж, сонголт хийх гэх мэт чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг. Мөн тус хорооны бүрэлдэхүүнийг ТУЗ-ийн 2024 оны 04 сарын 24-ний өдрийн 24/19 дугаар тогтоолоор баталсан байна.

ТУЗ-ийн гишүүдийн ирц, ажилласан хугацаа болон бусад мэдээлэл

ТУЗ-ийн гишүүдийн нэрс	2024 оны ТУЗ-ийн хурлын ирц	ТУЗ-д ажилласан хугацаа, туршлага	Үнэлгээний хувь
О.Болдбаатар	100%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 7 дахь жилдээ ажиллаж байна.	57,097 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт хувьцааны 0.0077%
С.Энх-Амгалан	100%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 7 дахь жилдээ ажиллаж байна	Үгүй
Кацухико Мадоно	100%	ХЭЭХ-аас сонгогдож, эхний жилдээ ажиллаж байна	Үгүй
Ц.Одмаа	92.3%	ХЭЭХ-аас сонгогдож, эхний жилдээ ажиллаж байна	Үгүй
Б.Хос-Эрдэнэ	84.6%	ХЭЭХ-аас сонгогдож, 3 дахь жилдээ ажиллаж байна	Үгүй
Ц.Ууганбаяр	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 3 дахь жилдээ ажиллаж байна	20,435 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт хувьцааны 0.0028%
Ж.Жаргалсүрэн	100%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 7 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	Үгүй
С.Боргил	100%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 7 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	7,076 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт хувьцааны 0.0010%
С.Нэргүй	100%	ХЭЭХ-аас сонгогдож, эхний жилдээ ажиллаж байна	9,000 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт хувьцааны 0.0012%

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн холбогдох журам, кодекс, түүнчлэн Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд аливаа шийдвэрийг хараат бусаар, бие даан гаргадаг. ТУЗ-ийн аливаа шийдвэр нь олонхын саналаар хүчин төгөлдөр болдог ба ТУЗ-ийн гишүүн нь хэлэлцэж буй асуудлаар "дэмжсэн", "татгалзсан", "түдгэлзсэн"

санал гаргах боломжтой. ТУЗ-ийн гишүүд нь тайлант хугацаанд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, хичээл зүтгэл гарган ажилласан гэдгийг ТУЗ-ийн хурлын ирцээс харж болох бөгөөд Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай, ач холбогдолтой шийдвэрүүдийг холбогдох баримт бичиг, судалгаа, тайлбар дүгнэлттэй нэг бүрчлэн танилцсаны үндсэн дээр цаг алдалгүй гаргаж, Компанийн 2024 оны амжилтын голлох хүчин зүйлсийн нэг болсон юм.

ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын мэдээлэл

Компанийн ТУЗ-ийн 2024 оны цалингийн хэмжээ, зарцуулах төсвийг 2024 оны 03 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан ХЭЭХ-аас баталсан билээ.

ТУЗ нь батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа ба нэмэлтээр шагнал, нөхөн олговор, бусад урамшуулал олгоогүй болно.

Зардлын зүйл	Гишүүдийн тоо	Сарын цалин (төгрөг)	Сар	Нийт төсөв (төгрөг)
Цалин урамшууллын төсөв	10	13,780,000	12	186,030,000
Дарга	1	1,950,000	12	23,400,000
Хорооны дарга	3	1,560,000	12	56,160,000
Гишүүн	5	1,300,000	12	78,000,000
Нарийн бичгийн дарга	1	650,000	12	7,800,000
НДШ-ийн зардал				20,670,000
Хурал болон бусад зардал				10,000,000
НИЙТ ТӨСӨВ				196,030,000

Дотоод аудит

Дотоод аудитын тогтолцоо: “ЛэндМН ББСБ” ХК нь Хамгаалалтын гурван бүс / Three lines of defence/ бүхий эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэн бүх нэгжийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулан ажилладаг.

Дотоод аудитын тогтолцоог харуулбал:



Дотоод аудитор нь хамгаалалтын гуравдугаар бүсэд хамаардаг бөгөөд нэг ба хоёрдугаар хамгаалалтын бүсийн хүрээнд хяналтын шаардлагууд биелж байгаа эсэхийг хараат бус, бодитой үнэлж дүгнэн

баталгаажуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд тайлагнаж, Гүйцэтгэх удирдлагад зөвлөгөө өгч хамтран ажиллах үүрэг хүлээдэг.

ЛэндМН-ийн удирдлагын баг



Ц.Ууганбаяр
“ЛэндМН ББСБ” ХК
Гүйцэтгэх захирал
“АНД Глобал” Пти.Лтд-д
8 жил ажилласан.



К.Мадоно
“ЛэндМН ББСБ” ХК
Ерөнхийлөгч
Банк, санхүүгийн салбарт
43 жил, “АНД Глобал” Пти.Лтд-д
6 жил ажилласан.



Д.Баасандорж
“ЛэндМН ББСБ” ХК
Дэд захирал
“АНД Глобал” Пти.Лтд-д 2 жил,
Банк, санхүүгийн салбарт 4 жил
ажилласан.



М.Түвшинжаргал
“ЛэндМН ББСБ” ХК
Санхүү, үйл ажиллагааны
газрын захирал
Банк, санхүүгийн салбарт
19 жил ажилласан.



Ж.Сосор
“ЛэндМН ББСБ” ХК
Бизнес хөгжлийн газрын захирал
Банк, санхүүгийн салбарт
17 жил ажилласан.



Г.Мөнхтулга
“ЛэндМН ББСБ” ХК
Хөрөнгө оруулалт хариуцсан захирал
Банк, санхүүгийн салбарт
14 жил ажилласан.



Х.Энхжаргал
“ЛэндМН ББСБ” ХК
Борлуулалт, хамтын ажиллагаа
хариуцсан захирал
Банк, санхүүгийн салбарт
18 жил ажилласан.




Э.Эрэлхэгзориг
“ЛэндМН ББСБ” ХК
Мэдээлэл технологийн хэлтсийн
захирал
Банк, санхүүгийн салбарт
20 жил ажилласан.



Б.Наранцацрал
“ЛэндМН ББСБ” ХК
Эрсдэлийн удирдлагын хэлтсийн
захирал
Банк, санхүүгийн салбарт
4.5 жил ажилласан.

КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Хувьцааны мэдээлэл



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж


2024 онд :

- Нийт арилжаалагдсан ширхэг - 29.1 сая ширхэг
- Нийт арилжаалагдсан үнийн дүн -2,676.1 сая төгрөг

Тайлант хугацаанд компани эргүүлэн худалдан авсан халаасны хувьцаа байхгүй ба ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх, урамшуулах хөтөлбөр хэрэгжүүлээгүй болно. 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн халаасны хувьцаа 60,698,317 ширхэг байна.

Ногдол ашгийн мэдээлэл

Нэгж хувьцаанд зарлагдсан
ногдол ашиг (Төг)



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Ногдол ашгийн бодлогын дагуу 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 24/03 тоот тогтоолоор “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 8.0 төгрөг буюу нийт 5,914,413,000 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсний дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан 2024 оны 04

дүгээр сарын 05-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг шилжүүлсэн билээ.

Мөн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 25/03 тоот тогтоолоор “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 15.0 төгрөг буюу нийт 11,089,525,245 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

 lendmn | **flexi**business

20 24 | Fintech Excellence Awards

Financial Inclusivity

төрөлд эцсийн
шатанд шалгарлаа



**“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2024
оны санхүүгийн хураангуй
тайлан, аудитын дүгнэлт**



“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК

РАССЕЛ БЕДФОРД ИНТЕРНЭШНЛ
Олон улсын сүлжээний гишүүн

2025.02.06 № 25/10
танай _____ -ны № _____ -т
АУДИТОРЫН ТАЙЛАН

“ЛэндМН ББСБ” ХК-ийн
Хувьцаа эзэмшигчдэд

Хараат бус аудитын дүгнэлтийн үргэлжлэл

Дүгнэлт

Бид “ЛэндМН ББСБ” ХК -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн Нэгтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний холбогдох тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “ЛэндМН ББСБ” ХК -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Нэгтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү дүгнэлтийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа, санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулахын тулд дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь ондор түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах.
- Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.

Хараат бус аудитын дүгнэлтийн үргэлжлэл

- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх.
- Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдлаа Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

(Энэхүү дүгнэлт нь хавсралтын хамт хүчин төгөлдөр болно.)

ЗАХИРАЛ


 Д.ШИЙРЭВ
 ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК
 9026010111 6821976 ШЖР1208
 MEMBER



НЭГТГЭСЭН АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ТАЙЛАН
 2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

"ЛэндМН ББСБ" ХК

/мян.төг/

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
Борлуулалтын орлого	88,801,668	47,982,386
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
Нийт ашиг (алдагдал)	88,801,668	47,982,386
Түрээсийн орлого	-	-
Хүүний орлого	388,368	29,685
Бусад орлого	271,656	149,139
Борлуулалт, маркетингийн зардал	425,855	482,738
Ерөнхий ба удирдлагын зардал	12,379,511	9,920,786
Санхүүгийн зардал	22,181,544	9,434,248
Бусад зардал	8,201,425	3,095,828
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-146,098	143,113
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	46,127,259	25,370,723
Орлогын татварын зардал	10,013,611	5,574,907
Татварын дараахь ашиг (алдагдал)	36,113,649	19,795,816
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	36,113,649	19,795,816
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	36,113,649	19,795,816

Нэгж хувьцаанд ногдох ашиг
 Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрсэн ашиг

төг	48.85	26.78
-----	-------	-------

НЭГТГЭСЭН АУДИТЛАГДСАН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

"ЛэндМН ББСБ" ХК

/мян.төг/

Балансын зүйл	2024.12.31	2023.12.31
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө	12,706,074	7,885,967
Дансны авлага	717,913	426,590
Бусад авлага	1,094,548	-
Зээл /цэврээр/	231,727,567	123,462,373
Бараа материал	4,116	15,613
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	392,103	55,975
Өмчлөх бусад хөдлөх хөрөнгө	11,000	15,080
Эргэлтийн хөрөнгийн дүн	246,653,321	131,861,598
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	4,942,878	1,251,811
Биет бус хөрөнгө	754,673	355,542
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,697,551	1,607,353
Нийт хөрөнгийн дүн	252,350,872	133,468,951
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	5,109,254	3,876,599
Цалингийн өглөг	-	309,972
Татварын өглөг	4,279,392	4,080,482
НДШ-ийн өглөг	-	38,505
Богино хугацаат зээл	75,329,520	8,124,018
Хүүний өглөг	-	1,474,622
Бусад богино хугацаат өр төлбөр	-	227,644
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	62,594,178	35,661,746
Богино хугацаат өр төлбөрийн дүн	147,312,344	53,793,589
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөр	2,945,392	20,350,164
Нөөц /Болзошгүй өр төлбөр /	113,351	
Хойшлогдсон татварын өр төлбөр	19,776	
Бусад урт хугацаат өр төлбөр	29,028,833	16,593,258
Урт хугацаат өр төлбөрийн дүн	32,107,353	36,943,422
Нийт өр төлбөрийн дүн	179,419,697	90,737,012
Өмч		
Хувьцаат	8,000,000	8,000,000
Халаасны хувьцаа	(2,337,547)	(2,337,547)
Нэмж төлөгдсөн капитал	2,756,859	2,756,859
Эздийн өмчийн бусад хэсэг	57,348	57,348
Хуримтлагдсан ашиг	64,454,515	34,255,279
Нийт өмчийн дүн	72,931,175	42,731,939
Нийт өр төлбөр ба өмчийн дүн	252,350,872	133,468,951



Зохистой харьцааны тайлан

"ЛэндМН ББСБ" ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-д заасны дагуу 2024 оны жилийн эцэст 5.9 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-н стандартын дагуу 13.2 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан.

Энэ нь зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээг 129%-д хүргэж ажиллалаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлаар компанийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хэлэлцдэг бөгөөд 2024 онд зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс харна уу.

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2022	2023	2024
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	28.1%	27.7%	25.7%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	31.5%	29.6%	26.7%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	31.5%	31.6%	29.3%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	12.0%	11.2%	8.0%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	-39.8%	-39.5%	-38.2%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	78.5%	79.7%	78.7%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	38.0%	26.5%	37.0%

**"Өмнө нь санхүүжилтээ
шийдэх гэж их цаг
алддаг байсан бол
одоо санаа зоволтгүй
болсон."**



flexibusiness

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүнд нэр дэвшиж буй нэр
дэвшигчдийн танилцуулга**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИЖ БҮЙ НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА



О.БОЛДБААТАР



Ц.УУГАНБАЯР



Б.ХОС-ЭРДЭНЭ



С.ЭНХ-АМГАЛАН



Ц.ОДМАА



К.МАДОНО



О.БОЛДБААТАР

Санхүүч, Аудитор, Олон улсын мэргэшсэн нягтлан бодогч

Боловсрол

1999-2004 онд “Турк улсын Босфорус их сургууль”, Бизнесийн удирдлагын бакалавр
 2010 он АНУ, Олон улсын мэргэшсэн нягтлан бодогч
 2014 он “Мэргэшсэн нягтлан бодогчдын институт”, Мэргэшсэн нягтлан бодогч
 2014 он “Мэргэшсэн нягтлан бодогчдын институт”, Мэргэшсэн аудитор

Ажлын туршлага

2004-2005 онд Турк Улсын Denge Denetim / Mazars, Аудитор
 2005-2006 онд Далайван Аудит ХХК, Ахлах аудитор
 2006-2009 онд Эрнст энд Янг Монголиа ХХК, Ахлах аудитор
 2009-2010 онд Малайз Улсын KPMG компани, Ахлах аудитор
 2010-2015 онд PwC Монголиа ХХК, Ахлах менежер
 2015-2016 онд PwC Их Британи компани, Менежер
 2017-одоо хүртэл АНД Глобал Пти.Лтд, ТУЗ-ийн гишүүн
 2017-одоо хүртэл АНД Эф Эс Жи Пти.Лтд, Гүйцэтгэх захирал
 2019-2021 онд “ЛэндМН ББСБ” ХК, Гүйцэтгэх захирал
 2020-одоо хүртэл “Ондо” ХХК, Үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн гишүүн
 2021-одоо хүртэл “ЛэндМН ББСБ” ХК, ТУЗ-ийн дарга



Ц.УУГАНБАЯР

Санхүүч

Боловсрол

2006-2010 онд Болгар Улс, Америкийн Их сургууль, Бизнесийн удирдлага (Нягтлан бодох бүртгэл), Эдийн засгийн ухааны бакалавр

Ажлын туршлага

2008 он Марта Вайняард Хадгаламжийн банк, Теллер
 2009 он Америкийн Нэгдсэн Улс, Эдгартаун Үндэсний Банк, Нягтлан бодогч / дадлага /
 2010-2018 онд Эм Си Эс Холдинг ХХК, Санхүүгийн ахлах ажилтан
 2018-одоо хүртэл АНД Глобал Пти.Лтд, Санхүүгийн менежер, Санхүү эрхэлсэн захирал
 2022-одоо хүртэл АНД Системс ХХК, ТУЗ-ийн гишүүн
 2023-одоо хүртэл “ЛэндМН ББСБ” ХК, Гүйцэтгэх захирал



Б.ХОС-ЭРДЭНЭ

Санхүүч, Бизнесийн удирдлага

Боловсрол

2004-2007 онд Шинэ Монгол сургууль, Ерөнхий боловсрол
 2007-2008 онд Санхүү, эдийн засгийн дээд сургууль
 2008-2009 онд Япон Улс, Токёогийн гадаад судлалын их сургууль, Япон хэлний бэлтгэл
 2009-2013 онд Япон Улс, Хитоцүбаши их сургууль, Хөрөнгийн зах зээл, санхүү бакалавр
 2012-2014 онд Япон Улс, Хитоцүбаши их сургууль, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага

2014-2016 онд Япон дахь Швейцари Улсын хөрөнгө оруулалтын банк UBS Секьюритис, Хөрөнгийн зах зээлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч банкир
 2016-2018 онд Япон Улс, Мизухо банк, Байгууллагын судалгааны газар, Бизнес шинжээч
 2018-2020 онд АНД Глобал Пти.Лтд, Хөрөнгө оруулалт хариуцсан захирал
 2020-одоо хүртэл АНД Глобал Пти.Лтд, Гүйцэтгэх захирал
 2021-одоо хүртэл АНД Системс ХХК, Гүйцэтгэх захирал



С.ЭНХ-АМГАЛАН

Олон улсын харилцаа, олон улсын бодлого судлаач

Боловсрол

1993-1997 онд Монгол Улсын их сургуулийн Олон улсын харилцаа бакалавр
 1999-2001 онд АНУ-ын Монтерейн ОУХДС, Олон улсын бодлого судлалын магистр

Ажлын туршлага

2004-2010 онд М-Си-Эс группын охин компаниуд, Дэд захирал / Гүйцэтгэх захирал
 2010-2012 онд Mongolian Mining Corp, Энержи ресурс ХХК, Дэд ерөнхийлөгч
 2012-2013 онд Клин Энержи ХХК, Гүйцэтгэх захирал
 2013-2015 онд Southgobi Sands & Southgobi Resource ХК, Ерөнхийлөгч / Гүйцэтгэх захирал
 2015-2016 онд Эрдэнэс Монгол ХХК, Зөвлөх
 2017-2021 онд Петровис ойл ХХК, Ерөнхий захирал
 2021-одоо хүртэл Мэргэн Инвестмент Пти.Лтд, ТУЗ-ийн гишүүн
 2023-одоо хүртэл “Монложистикс Холдинг” ХК, ТУЗ-ийн гишүүн



Ц.Одмаа

Хуульч, Өмгөөлөгч



Боловсрол

- 1998 – 2002 онд Шихихутуг Хууль зүйн дээд сургууль, Хууль зүйн бакалавр
- 2006-2007 онд Удирдлагын Академи, Төрийн удирдлагын мэргэшүүлэх диплом
- 2010 он Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч
- Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч
- 2011 он Япон Улс, Европын холбооны дээд сургууль, Европын холбооны Худалдааны тухай хууль / мэргэшүүлэх диплом
- 2010-2011 онд Япон улсын Кьюшугийн Их Сургууль, Хууль зүйн магистр

Ажлын туршлага

- 2007-2008 онд Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн салбарын хөгжлийн хөтөлбөрийн нэгж, Туслах хуульч
- 2009-2012 онд Монгол Улсын Хууль зүйн Яамны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэн, Судлаач / Ахлах судлаач
- 2013-2019 онд “ЭмДиЭс энд Хаанлекс” ХХН , Удирдах гишүүн
- 2019-2021 онд “АНД Системс” ХХК, Гүйцэтгэх захирал
- 2021-2022 онд “ЛэндМН ББСБ” ХК, ТУЗ-ийн гишүүн/дарга
- 2021-2023 онд “ОНДО” ХХК, Хуулийн газрын захирал
- 2023- одоо хүртэл “ОНДО Холдинг” ХХК, Хуулийн газрын захирал



К.МАДОНО

Мэргэжлийн туршлага


Банк санхүүгийн салбарт 27 жил ажилласан туршлагатай (Хилийн чанад дахь бизнес хөгжүүлэлт, төлөвлөлт чиглэлээр голчлон ажилласан).

Бизнесийн стратеги, брэндинг, маркетинг, хүний нөөцийн хөгжил, менежмент, мэдээллийн технологийн системийн стратегийн чиглэлээр өргөн хүрээний баялаг туршлагатай. Зүүн Өмнөд Ази дахь бизнесийн зах зээлийн үнэлгээний судалгааг удирдан ажилласан.

Ажлын туршлага

- 1996 он Тайланд Улс, ITOCHU-тай хамтран EASY BUY компанийг үүсгэн байгуулагч
- 1998 он Тайланд Улс, EASY BUY компанийн Гүйцэтгэх захирал
- 2009 он Тайланд Улс, EASY BUY компанийн ТУЗ-ийн дарга
- 2014 он Тайланд Улс, AIFUL компанийн Ерөнхий зөвлөх
- 2014 он Тайланд Улс, AIFUL компанийн Гүйцэтгэх захирал
- 2019 он Тайланд Улс, Aira & Aiful-ийн Гүйцэтгэх захирлын зөвлөх
- 2022- одоо хүртэл Монгол Улс, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Ерөнхийлөгч

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИЖ БУЙ НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА



Ж.ЖАРГАЛСҮРЭН



С.БОРГИЛ



С.НЭРГҮЙ



Ж.ЖАРГАЛСҮРЭН

Санхүүч, Аудитор, Олон улсын мэргэшсэн нягтлан бодогч

Боловсрол

- 1998 он Мандах бүртгэл дээд сургууль, Нягтлан бодох бүртгэлийн бакалавр
- 2000 он Санхүү, эдийн засгийн дээд сургууль, Бизнесийн удирдлагын магистр
- 2000 он Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Мэргэшсэн нягтлан бодогч
- 2011 он Их Британи, Олон улсын мэргэшсэн нягтлан бодогчдын нийгэмлэг, Олон улсын мэргэшсэн нягтлан бодогч
- 2015 он Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Татварын мэргэшсэн зөвлөх

Ажлын туршлага

- 1998-2003 онд Санхүү, эдийн засгийн дээд сургууль, Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш
- 2003-2005 онд Далайван аудит ХХК, Аудитор
- 2005-2015 онд Далайван аудит ХХК, Аудитын менежер
- 2015-одоо хүртэл Бейкер Тилли Далайван аудит ХХК, Удирдлагын партнер/Гүйцэтгэх захирал



С.БОРГИЛ

Эдийн засагч, Санхүүч

Боловсрол

- 1991-1995 онд Монгол Улсын их сургуулийн Эдийн засгийн сургууль, Санхүүгийн бакалавр
- 1999-2003 онд АНУ-ын Колорадогийн их сургууль, Эдийн засгийн магистр / эконометрик болон санхүү /

Ажлын туршлага

- 1995-1997 онд Сангийн яам, Санхүүгийн байгууллагуудын хэлтсийн эдийн засагч
- 1997-1999 онд Сангийн яам, Төсвийн зарлагын хэлтсийн дарга
- 2003-2004 онд АНУ-ын Community First National Bank, зээлийн шинжээч
- 2004-2012 онд АНУ-ын Жиллет банк, Дэд ерөнхийлөгч / Ерөнхийлөгч
- 2013-2015 онд Уул уурхай, хөнгөн үйлдвэрийн яам, Эрдэнэс Оюу Толгой ХХК, Зөвлөх
- 2013-2015 онд Ирээдүйн өв сангийн тухай хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүн
- 2015-2017 онд Сангийн яам, Зөвлөх
- 2017-одоо хүртэл Сэргэлт консалтинг групп ХХК, Гүйцэтгэх захирал



С.НЭРГҮЙ

Санхүүч, Санхүүгийн мэргэшсэн зөвлөх

Боловсрол

- 1982-1987 онд МУ, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль, Орос хэл судлал, Бакалавр, Магистрын зэрэг
- 1992-1995 онд МУ, Завхан аймаг Эдийн Засгийн Коллеж, Эдийн засаг / Санхүүгийн бакалавр
- 2000-2004 онд АНУ, Брандейсийн их сургуулийн Хеллерийн Нийгмийн бодлого, менежментийн сургууль, Олон Улсын Тогтвортой Хөгжлийн Магистр

Ажлын туршлага

- 2000-2002 НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP)-ийн “Ядуурлыг бууруулах хөтөлбөр” / Киргизстан /- Бүс нутгийн хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн менежер, “Бичил зээлийн хөтөлбөр” / Каракалпакистан, Кашкадарай муж, Узбекистан /- Бичил зээл, орон нутгийн хөгжлийн мэргэжилтэн
- 2005-2008 онд МУ, Ачид Финанс ХХК, Орон нутгийн санхүүгийн багийн ахлагч
- 2008-2010 онд МУ, АНУ-ын Мянганы сорилтын сан, Хөгжлийн туслах мэргэжилтэн
- 2010-2011 онд “Сургалт үнэлгээ судалгааны хүрээлэн” НҮТББ, Үүсгэн байгуулагч, Захирал
- 2011-2014 онд Банк санхүүгийн академи, Гүйцэтгэх захирал
- 2014-2018 онд “Ричфинанс ББСБ” ХХК, Захирал
- 2018- одоо хүртэл “Сургалт үнэлгээ судалгааны хүрээлэн” НҮТББ, Захирал, Ахлах зөвлөх

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН САНАЛ

Хэлэлцэх асуудал	Гишүүдийн тоо	Сарын цалин (₮)	Сар	Нийт төсөв (₮)
1 Цалин урамшууллын төсөв	10	13,780,000	12	186,030,000
1.1 Дарга	1	1,950,000	12	23,400,000
1.2 Хорооны дарга	3	1,560,000	12	56,160,000
1.3 Гишүүн	5	1,300,000	12	78,000,000
1.4 Нарийн бичгийн дарга	1	650,000	12	7,800,000
1.5 НДШ-ийн зардал				20,670,000
2 Хурал болон бусад зардал				10,000,000
НИЙТ ТӨСӨВ				196,030,000

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны ТӨСВИЙН САНАЛ

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

№ 25/01

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны
тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалт болон 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Компанийн ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА

О.БОЛДБААТАР

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

№ 25/02

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг улируулан сонгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1, 77.2 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг болон 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр дараах нэр дэвшигчдийг улируулан сонгосугай.
 - 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн гишүүн:
 - 1.1.1. Монгол Улсын иргэн Очирсүрэн овогтой Болдбаатар
 - 1.1.2. Монгол Улсын иргэн Цэрэндорж овогтой Ууганбаяр
 - 1.1.3. Монгол Улсын иргэн Баатархүү овогтой Хос-Эрдэнэ
 - 1.1.4. Япон Улсын иргэн Кацухико Мадоно
 - 1.1.5. Монгол Улсын иргэн Цэвэгжав овогтой Одмаа
 - 1.1.6. Монгол Улсын иргэн Сэнгээ овогтой Энх-Амгалан
 - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн:
 - 1.2.1. Монгол Улсын иргэн Жигдэн овогтой Жаргалсүрэн
 - 1.2.2. Монгол Улсын иргэн Сүрэнхүү овогтой Боргил
 - 1.2.3. Монгол Улсын иргэн Сандагжав овогтой Нэргүй
2. Компанийн дүрмийн 9.3-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 1 (нэг) жил буюу дараа жилийн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл үргэлжлэхийг дурдсугай.
3. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад Компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг улируулан сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн болон Хараат бус гишүүдэд үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА

О.БОЛДБААТАР

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

№ 25/03

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны төсвийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.11 дэх заалт болон 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралтад заасны дагуу баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА

О.БОЛДБААТАР

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ТӨСӨВ**

No	Зардлын зүйл	Гишүүдийн тоо	Сарын цалин (төгрөг)	Сар	Нийт төсөв (төгрөг)
1	Цалин урамшууллын төсөв	10	13,780,000	12	186,030,000
1.1	Дарга	1	1,950,000	12	23,400,000
1.2	Хорооны дарга	3	1,560,000	12	56,160,000
1.3	Гишүүн	5	1,300,000	12	78,000,000
1.4	Нарийн бичгийн дарга	1	650,000	12	7,800,000
1.5	НДШ-ийн зардал				20,670,000
2	Хурал болон бусад зардал				10,000,000
	НИЙТ ТӨСӨВ				196,030,000

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

№ 25/04

Улаанбаатар хот

**Компанийн дүрэмд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1, 8.5.1 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг болон 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

- Компанийн дүрэмд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.
 - Компанийн дүрмийн 2.2 дахь хэсгийг
“Компанийн төв байр дараах хаягт оршин байрлана:
Улаанбаатар хот, 3-р хороо, 5-р хороолол /14252/ Сөүлийн гудамж 13А хаягт байрлах
“Алтан Жолоо Тауэр” оффис 10 давхар 01 тоот
гэж өөрчлөх буюу хаягийн өөрчлөлт оруулах;
 - Компанийн дүрмийн 4.2.10 дахь хэсэгт “Төлбөрийн баталгаа гаргах” гэж нэмэх буюу үйл ажиллагааны чиглэлийг нэмэх;
- Энэхүү шийдвэрийн 1 дэх хэсэгт заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг энэхүү шийдвэрийн Хавсралтаар баталсугай.
- Энэхүү шийдвэрийн 1 дэх хэсэгт заасны дагуу үйл ажиллагааны чиглэл нэмэх, Компанийн албан ёсны хаяг өөрчлөхтэй холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооноос холбогдох зөвшөөрөл хүсэх, шаардлагатай баримт бичгийг баталгаажуулах, бүрдүүлж өгөх, эдгээртэй холбоотой бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
- Энэхүү шийдвэрийн Хавсралтаар батлагдсан Компанийн дүрмийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, тийнхүү бүртгүүлэхтэй холбоотой аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Компанийн Хууль, хянан нийцүүлэлтийн мэргэжилтэн (Х.Хулан /РД:...../, М.Маралмаа /РД:/-)–д үүрэг болгосугай.
- Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааны чиглэл нэмэгдэж буйтай холбогдуулан шаардлагатай шийдвэр, журам баталж, мөрдүүлэн ажиллахыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА

О.БОЛДБААТАР



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 25/07 тоот тогтоолын
ХАВСРАЛТ №5а

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС - А**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:

Регистрийн дугаар:

Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа бол:
Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр, регистрийн дугаар:

Эзэмшиж буй хувьцааны төрөл: **Энгийн**
Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг):

Санал хураах арга: **Кумулятив**

Тайлбар: ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгож, бүрэн эрхийн хугацааг сунгахад таны өгөх нийт саналын эрхийн тоо нь таны эзэмшиж буй хувьцааны тоог улируулан сонгох ТУЗ-ийн гишүүдийн тоо буюу 9-өөр үржүүлсэнтэй тэнцэх бөгөөд энэхүү тоо нь үүнээс их болон бага байх тохиоддолд таны санал хүчингүйд тооцогдохыг анхаарна уу.

Кумулятив аргаар санал хураах жишээ:

Хэрэв та 100 ширхэг хувьцаа эзэмшдэг бол таны өгөх нийт санал нь таны эзэмшиж буй хувьцааны тоо буюу 100-г ТУЗ-ийн улируулан сонгох гишүүдийн тоо буюу 9-өөр үржүүлж нийт 900 саналын эрхтэй. Үүний 600 саналын эрхийг ТУЗ-ийн ердийн 6 гишүүнд, 300 саналын эрхийг ТУЗ-ийн хараат бус 3 гишүүнд тус тус 3 хувааж өгнө. Гэхдээ 900 саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон тодорхой нэг гишүүнд, эсвэл хэд хэдэн гишүүнд дурын харьцаагаар хуваан өгч болно. **Харин таны нийт саналын эрхийн тоо 900-аас их буюу бага байж болохгүй.**

№	Хэлэлцэх асуудал	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Саналын эрхийн тоо
1	ТУЗ-ийн ердийн гишүүдийг улируулан сонгох	ТУЗ-ийн ердийн гишүүн Очирсүрэнгийн БОЛДБААТАР ТУЗ-ийн ердийн гишүүн Цэрэндоржийн УУГАНБАЯР ТУЗ-ийн ердийн гишүүн Баатархүүгийн ХОС-ЭРДЭНЭ ТУЗ-ийн ердийн гишүүн Кацухико МАДОНО ТУЗ-ийн ердийн гишүүн Цэвэгжавын ОДМАА ТУЗ-ийн ердийн гишүүн Сэнгээгийн ЭНХ-АМГАЛАН	
2	ТУЗ-ийн хараат бус гишүүдийг улируулан сонгох	ТУЗ-ийн хараат бус гишүүн Жигдэнгийн ЖАРГАЛСҮРЭН ТУЗ-ийн хараат бус гишүүн Сүрэнхүүгийн БОРГИЛ	

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын санал авах хуудас

		ТУЗ-ийн хараат бус гишүүн Сандагжавын НЭРГҮЙ	
3	Нийт саналын эрхийн тоо		

Хувьцаа эзэмшигч иргэн: _____
Гарын үсэг: _____


Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж Гарын үсэг: _____
хуралд оролцсон төлөөлөгч: Албан тушаал: _____

Брокерийн гарын үсэг (тамга): _____
Саналын хуудас хүлээн авсан огноо, цаг: _____

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын Дарга: _____
Гишүүн: _____
Гишүүн: _____

Хэрэв хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 25/07 тоот тогтоолын
ХАВСРАЛТ №56

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС - Б**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____
Регистрийн дугаар: _____
Эзэмшиж буй хувьцааны төрөл: _____ Энгийн
Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг): _____
Үнэт цаасны дансны дугаар: _____
Бүртгэсэн ҮЦК-ийн нэр: _____
Брокерийн овог, нэр: _____

№	Хэлэлцэн батлах асуудал	Хувьцаа эзэмшигчийн санал			
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан бол таны өгөх санал
1	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах				
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг батлах				
3	Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлах. Үүнд: 3.1. Компанийн дүрмийн 2.2 дахь хэсэгт “Улаанбаатар хот, Сүхбаатар лүүрэг, 3-р хороо, 5-р хороолол /14252/ Сөүлийн гудамж 13а, “Алтан Жолоо Тауэр” оффис 10 давхрын 01 тоот” гэж өөрчлөлт оруулах буюу хаяг өөрчлөх; 3.2. Компанийн дүрмийн 4.2.10 дахь заалтад “Төлбөрийн баталгаа гаргах” гэж нэмэх.				

Хувьцаа эзэмшигч иргэн: _____
Гарын үсэг: _____

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж Гарын үсэг: _____
хуралд оролцсон төлөөлөгч: Албан тушаал: _____

Брокерийн гарын үсэг (тамга): _____

Саналын хуудас хүлээн авсан огноо, цаг: _____

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын Дарга: _____
 Гишүүн: _____
 Гишүүн: _____

Хэрэв хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

Санал авах хуудас ашиглах дараах санамжтай танилцана уу!

Санал авах хуудас ашиглах санамж

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгтээ (+) тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (+), татгалзсан эсхүл түдгэлзсэн бол харгалзах нүдэнд (+) тэмдэг тавина.
2. Санал авах хуудасны эхний хэсгийг зуучлагч үнэт цаасны компанийн тэмдэг даран баталгаажуулж хувьцаа эзэмшигчдэд өгнө.
3. Засварласан, Балласан болон залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хувьцаа эзэмшигчид нь 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн дотор хурлын материалтай танилцах бөгөөд хэрэв Та хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол санал авах хуудсанд саналаа тэмдэглэн, үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 18:00 цагаас өмнө хүргүүлнэ.
5. Хэрэв Та саналаа итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэх бол итгэмжлэгдсэн этгээдийн мэдээллийг дор бичиж, итгэмжлэлийн хамт саналын хуудсыг ирүүлнэ үү.


Таныг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлэл: _____
 Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр: _____
 Итгэмжлэгдсэн толоологчийн регистрийн дугаар: _____
 Хувьцаа эзэмшигч буюу таны нэр: _____
 Таны эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг): _____
 Гарын үсэг: _____


Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах газрын мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХУРАЛДАХ ГАЗАР



Галлериа Улаанбаатар төв (Gallery Ulaanbaatar Center)-ийн
3 давхарт байрлах Juulchin Ballroom танхимд
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий Сайд Амарын Гудамж-2





ВЕБСАЙТ:

www.lend.mn

УТАС:

7707-0101

ИМЭЙЛ:

board@lend.mn

2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал бэлтгэсэн:
Маркетингийн хэлтсийн менежер Б.Батбилэг
Хянасан: Санхүү, үйл ажиллагааны газрын захирал М.Түвшинжаргал